

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/027/НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНХАНГАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272248 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.03.24 № 01/257
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

ТӨВ АЙМГИЙН БАЯНХАНГАЙ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.БОЛОРТУЯА ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнаж, иргэдийн оролцоонд тулгуурлан сумынхаа нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжиж, төрийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх мөн иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлсэн, ил тод, хариуцлагатай, иргэн төвтэй төрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага болно гэсэн зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Аудитын гол асуудал

Баянхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 777,093.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тодотгон баталснаас 630,843.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 81,2 хувиар биелүүлж, 18,8 хувиар буюу 9 нэр төрлийн орлогыг нийт 188,036.9 мянган төгрөгөөр тасалсан байна.

• 4126020617

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Баянхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 18-ны 01 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 3 зорилт 196 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 73,1%-тай буюу "Үр дүнд хүрсэн" гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	646,213.85	688,482.03
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	118,066.42	181,010.49
3	1.1.3 АВЛАГА	408,173.98	344,958.72
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	119,973.45	162,512.81
5	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,306,297.84	1,520,699.59
6	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,306,297.84	1,520,699.59
7	1.2.2.02 Биет хөрөнгө	1,251,588.43	1,466,608.59
8	1.2.2.03 Биет бус хөрөнгө	54,709.42	54,091
9	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	1,952,511.69	2,209,181.62
10	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,472.58	82,246.57
11	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,472.58	82,246.57
12	2.1.1.03 Өглөг	15,472.58	82,246.57
13	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,937,039.12	2,126,935.05
14	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	1,937,039.12	2,126,935.05
15	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	378,389.05	378,389.05
16	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	1,284,212.25	1,475,684.55
17	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	274,437.82	272,861.45
18	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	1,952,511.69	2,209,181.62

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,487,076.54	2,563,260
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	375,185.32	362,839.86
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	310,545.13	304,448.05
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	310,545.13	304,448.05
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	38,280.53	36,815.94
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	26,359.66	21,575.87
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	602,404.89	2,200,420.14
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0	1,309,226.53
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,509,486.33	0
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,235,426.96	2,304,686.57
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,044,726.96	2,035,176.57
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,973,860.67	1,983,771.14
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	735,386.24	843,110.2
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,397.05	104,377.39
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	488,752.57	556,428.83
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	124,128.96	103,665.74
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал	13,613.92	0
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	33,361.8	11,145.5
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	13,756	10,069.9
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,978.84	3,928.99
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	468,485.29	351,044.58
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,866.3	51,405.43
23	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	190,700	269,510
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	251,649.57	258,573.43
25	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	22.5	68,677.5
26	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-22.5	-68,677.5
27	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	251,627.07	189,895.93

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,264,631.09	2,244,375.58
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	375,185.32	362,839.86
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	310,545.13	304,448.05
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	38,280.53	36,815.94
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	26,359.66	21,575.87
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	11,137.53	8,126.4
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	15,222.13	13,449.47
8	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	379,959.44	1,881,535.73
9	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	379,959.44	438,639.59
10	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0	1,307,226.53
11	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	135,669.6
12	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,509,486.33	0
13	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,825,020.49	1,812,375.8
14	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,825,020.49	1,812,375.8
15	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,753,599.19	1,760,914.23
16	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	738,755.1	846,633.37
17	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,419.49	104,377.39
18	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	499,513.82	556,052.33
19	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	50,428.16	39,959.47
20	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	95,185.2	112,342.56
21	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	54,058.4	23,938.5
22	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	13,756	10,069.9
23	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,980.06	2,452.99
24	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	196,502.97	65,087.71
25	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,421.3	51,461.57
26	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	439,610.6	431,999.78
27	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	290,637.4	367,443.51
28	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	290,637.4	367,443.51
29	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	290,637.4	367,443.51
30	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-290,637.4	-367,443.51
31	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,268	1,612.2
32	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-100,268	-1,612.2
33	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	48,705.2	62,944.07
34	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	69,361.22	118,066.42
35	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	118,066.42	181,010.49

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,683,974.14	1,683,974.14
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,437.91	1,437.91
3	1.1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,685,412.04	1,685,412.04
4	1.1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	251,627.07	251,627.07
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,937,039.12	1,937,039.12
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,937,039.12	1,937,039.12
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,576.37	1,576.37
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,938,615.49	1,938,615.49
9	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,576.37	-1,576.37
10	1.7 Тайлант үеийн үр дүн	189,895.93	189,895.93
11	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,126,935.05	2,126,935.05

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,912,670.20	3,558,627.43	354,042.77	91.0
2	11	3.1.01.1.1 Татварын орлого	506,517.70	362,839.86	143,677.84	71.6
3	110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	280,640.00	304,448.05	-23,808.05	108.5
4	1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	280,640.00	304,448.05	-23,808.05	108.5
10	113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	62,700.00	36,815.94	25,884.06	58.7
14	118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	163,177.70	21,575.87	141,601.83	13.2
15	1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	15,100.00	8,126.40	6,973.60	53.8
18	1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	43,677.70	13,449.47	30,228.23	30.8
20	1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	104,400.00	-	104,400.00	0.0
22	12	3.1.01.1.2 Татварын бус орлого	3,406,152.50	3,195,787.57	210,364.93	93.8
23	120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	300,156.00	331,282.49	-31,126.49	110.4
28	122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	2,969,316.90	2,728,835.49	240,481.41	91.9
31	123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	136,679.60	135,669.60	1,010.00	99.3
33	II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,120,261.30	1,802,285.98	317,975.32	85.0
34	21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,753,449.20	1,603,090.34	150,358.86	91.4
35	210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,700,353.20	1,551,628.76	148,724.44	91.3
36	2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	767,527.50	755,419.41	12,108.09	98.4
41	2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,710.40	93,812.63	1,897.77	98.0
47	2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	565,086.40	556,052.33	9,034.07	98.4
51	2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	45,780.30	39,103.95	6,676.35	85.4
56	2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	3,777.70	2,581.50	1,196.20	68.3
58	2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	44,100.00	30,528.20	13,571.80	69.2
62	2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	17,700.00	10,069.90	7,630.10	56.9
64	2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,800.00	2,452.99	17,347.01	12.4
70	2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	140,870.90	61,607.86	79,263.04	43.7
73	213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,096.00	51,461.57	1,634.43	96.9
76	2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	53,096.00	51,461.57	1,634.43	96.9
80	22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	283,656.10	197,583.44	86,072.66	69.7
84	23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	83,156.00	1,612.20	81,543.80	1.9
89	4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	108,809.01		
90	5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	179,026.48		
91	6	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	58	56	2	96.6
92	61	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0	100.0
94	62	6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО	28	27	1	96.4
99	65	6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28	27	1	96.4

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	359,471.23	264,515.00
2	12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	359,471.23	264,515.00
3	122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	359,471.23	264,515.00
4	1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	359,471.23	264,515.00
5	II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	313,290.15	264,515.00
6	21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	313,290.15	101,333.70
7	210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	313,290.15	101,333.70
8	2101	1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	78,334.87	87,749.40
9	2102	1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,685.52	10,564.80
10	2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	5,143.00	944.50
11	2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	510.00	-
12	2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	564.32	-
13	2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	219,052.45	2,075.00
14	213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,181.07	-
15	2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	37,111.23	-
16	2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,069.84	-
17	22	1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		163,181.30
18	2200	1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр		163,181.30

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Аудитаар нийт 121,753.4 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

3.1 Залруулсан алдаа:

1.Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн татварын болон татварын бус орлого тодотгон батлагдсан төлөвлөгөөнөөс 3 нэр төрлийн орлого 121,753.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Нийт алдаа, зөрчлөөс 188,036.9 мянган төгрөгийн зөрчил нь материаллаг бус, урьдчилан тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшин 31,803.9 мянган төгрөгөөс бага буюу материаллаг алдаа илрээгүй тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 188,036.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 188,036.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

3.2 Зөвлөмж

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд орон нутагт төвлөрүүлэх 9 нэр төрлийн орлогыг 188,036.9 мянган төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын тасалдлыг бууруулахын тулд төлөвлөлтийг бодитой болгох, биелэлтийг улирал тутам дүгнэж орлогын төлөвлөгөө жигд ханган биелүүлэх.

2. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд тус Засаг дарга шилэн дансны 159 мэдээлэл байршуулахаас 128 мэдээлэл хугацаанд нь, хугацаа хоцроосон 31 мэдээлэл, хугацаа хоцролтын хэрэгжилт 77,2%-тай байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 04 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалт тай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1			1			
3	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
4	Эмийн эргэлтийн сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	НИЙТ	5	1	4		1			

7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	2	177,181.4			2	177,181.4	2	177,181.4		
ИТХ	1	1,319.9			1	1,319.9	1	1,319.9		
ХХС	1	1,962.6			1	1,962.6	1	1,962.6		
ОНХС	1	10,650.1	1	10,650.10			1	10,650.1		
Дүн	5	191,114.0	1	10650.1	4	180,463.9	5	191,114.0		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ	2	2,334.0	1	100.0			1	2,234.0
ЗДТГ	4	140,575.6			2	7,882.5	2	132,693.1
Хоршоо хөгжүүлэх сан	2	88,870.0	1	1,122.5			1	87,747.5
ЭЭС	3	59,452.5	1	138.6	1	1,632.0	1	57,681.9
Дүн	11	291,232.1	3	1,361.1	3	9,514.5	5	280,356.5

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ИТХ	1						1	
ЗДТГ	1						1	
ХХС	1						1	
Дүн	3						3	

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn